

АВЛИГЫН ХОР, ХӨНӨӨЛ

- ✓ Авлига нь хувь хүний, гэр бүлийн, нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг. Төрөөс авах ёстой үйлчилгээг хүртэж чадахгүй нэмэлт зардал гаргах нь иргэдийн амьдралд хүнд ачаа болдог.
- ✓ Цөөн тооны хүмүүст давуу эрх ашиг олгож, тэгш бус байдлыг хөхиүлэн дэмжиж, нийгэмд шударга өрсөлдөөнийг бий болгоход саад учруулж, үүгээрээ улс орны хөгжлийг хойш нь татаж байгаа явдал юм.

Авлигын эсрэг хамтдаа тэмцсэнээр

- ✓ Нийгэм, эдийн засгийн хөгжлийн таатай нөхцөл бүрдэнэ.
- ✓ “Авлигын татвар” төлөх шаардлагагүй болсноор бизнес эрхлэгчдэд өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж нээгдэнэ.
- ✓ Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- ✓ Шударга ёсыг бэхжүүлнэ.

Авлигаас татгалзсанаар Та олон мянган хүний адил шударга ёс, хариуцлагын тогтолцоог дэмжиж буй хэрэг билээ.



**ХЭРЭВ ТА АВЛИГЫН ТАЛААР
МЭДЭЭЛЬЕ ГЭВЭЛ ДООРХ УТСАНД
ХАНДАНА УУ**



1969 (энгийн утаснаас 10 төгрөг),
311919-т хангаарай.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар,
Сүхбаатар дүүрэг, Соёлийн гудамж-41

Утас: 70112474

Факс: 70112458

Шуудан: 44 дүгээр салбар

428 тоот хайрцаг

Цахим хуудас: www.iaac.mn



**МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

АВЛИГА
Таны **ҮГҮЙ** чухал

**АВЛИГА-ТАНЫ
ҮГҮЙ ЧУХАЛ**

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олоннийтийг соёнгэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, зарим төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн.



АВЛИГА ГЭЖ ЮУ ВЭ?

“Авлига” гэж Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.

- ✓ “ашиг хонжоо” гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
- ✓ “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;
- ✓ “давуу байдал” гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

Төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, хуулийн этгээдийн эрх

- ✓ шаардлагатай мэдээллээ авч чадахгүй байгаа тохиолдолд холбогдох албан тушаалтанд гомдол гаргах;
- ✓ төрийн байгууллагад хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийнхээ хариуг хуулийн хугацаанд нь авах;
- ✓ төрийн үйлчилгээ авахдаа тухайн албан хаагчтай хамт хооллох, өөрийн унаагаар үйлчлэх, гар цайлгахгүйгээр асуудлыг хуулийн дагуу шийдүүлэх;
- ✓ хууль бус нэмэгдэл төлбөр, хураамж төлөхгүй байх;
- ✓ тухайн байгууллагын үйлчилгээний талаарх санал хүсэлтээ илэрхийлэх
- ✓ төрийн байгууллагаар хөнгөн шуурхай үйлчлүүлэх



Авлигын хор хөнөөл

- **Нийгмийн шударга ёсыг алдагдуулдаг.**

Авлига нь цөөн тооны хүмүүст давуу байдал олгож, тэгш бус харилцааг өөгшүүлсээр байна.

- **Иргэдийн амьдралд дарамт учруулдаг.**

Төрийн үйлчилгээ иргэдэд нэмэлт зардалтайгаар хүрэх нь тэднийг өдөр тутам бухимдуулсаар байгаа билээ.

- **Иргэн бүр “авлигын татвар төлөгч” болно.**

Бизнес эрхлэгчид авлига, хүнд сурталд зарцуулсан мөнгөө бараа, бүтээгдэхүүнийхээ үнэд шингээн борлуулснаар иргэн бүр “авлигын татвар төлөгч” болон хувирч байна.

- **Улс орны эдийн засгийн хөгжил буурна.**

Нийгэм, эдийн засгийн хөгжилд зарцуулах хөрөнгө оруулалтыг эрх мэдэл бүхий цөөн хэдэн хүн завших нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулж, улмаар хөрөнгө оруулалт зогсоно.

АВЛИГА
Таны **ҮГҮЙ** чухал



1969

(энгийн утаснаас 10 төгрөг)

311919-т хандаарай

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар,
Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж-41

Утас: 7011-2474

Факс: 7011-2458

Шуудангийн хайрцаг: 44 дүгээр салбар
428 тоот хайрцаг

Цахим хуудас: www.iaac.mn



**АВЛИГА-ТАНЫ
ҮГҮЙ ЧУХАЛ**

1969

Авлигыг мэдээлэх утас

МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Авлигатай тэмцэх газар нь

- ✎ авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх
- ✎ авлигаас урьдчилан сэргийлэх
- ✎ авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах
- ✎ төрийн зарим албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага юм.

Авлига гэж юу вэ?

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг АВЛИГА гэнэ.

Та хэрхэн тэмцэж болох вэ?

Төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаалтан өөрийн эрх мэдлээ урвуулан ашиглаж буйг харсан, мэдсэн бол, мөн танд үзүүлж буй үйлчилгээндээ хүнд суртал гаргасан, авлигын нөхцөл, шалтгааныг бүрдүүлсэн шинжтэй байвал энэ утас руу залгаж гомдол, мэдээлэл өгч болно.

*Та ердөө 1969 рүү
залгахад л болно.*

Мэдээллийг яаж ашиглах вэ?

Таны өгсөн мэдээллийг авлигатай тэмцэхэд ашиглана.

Ирүүлсэн мэдээлэл гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол мөрдөн байцаалтад шилжүүлдэг.

Авлигатай тэмцэх газар таны өгсөн мэдээллийг чандлан нууцалж чадна.

Авлигын эсрэг хуулийн дагуу авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөх албан тушаалтнаас өөр хэн ч таны өгсөн мэдээллийн талаар мэдэх боломжгүй юм.

АВЛИГА, ХҮНД СУРТАЛ

байвал

1969

залга!

АВЛИГА
Таны **ҮГҮЙ** чухал

АВЛИГА-ТАНЫ ҮГҮЙ ЧУХАЛ